

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
2020 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	ЭХЯ-ны 2020.07.30-ны өдрийн 51/2020/87 тоот техникийн нөхцөл, ЭХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газарт 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр 155 тоот дугаартай албан бичгээр паркийн 110/35/10 кВ-ын цахилгаан хангамжийн өндөр хүчдэлийн агаарын шугамын зургийн даалгавар боловсруулж баталж өгөх хүсэлтийг хүргүүлсний дагуу 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр №2020/Ц-61 дугаартай “БҮТП” ОНӨТҮГ, “МЕСЕС” ХХК-ийн шинээр баригдах үйлдвэрүүдийн цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг баталж өгсөн. Тус батлагдсан ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг зураг төсөл гүйцэтгэгч байгууллагад хүргүүлэн цахилгаан хангамжийн урьдчилсан трассыг боловсруулан, дүүргийн дэд бүтцийн хангагч байгууллагууд болох ЦДҮС ТӨХК-ийн Зүүн өмнөд бүсийн салбар, Багануур дүүргийн онцгой байдлын хэлтэс, дүүргийн газар зохион байгуулалтын алба, Багануур ХК, БЗӨБЦТС ТӨХК-ийн холбогдох инженер, техникийн ажилтнуудтай уулзалт хийж, зөвшилцөн баталгаажуулж гүйцэтгэгч байгууллагад хүргүүлэн зураг төсөл боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэн хяналт тавьж ажиллаж байна.	100%
2.		Паркийн цахилгаан хангамжийн 110/35/10 кВ-ын 7,3 км цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн агаарын шугамыг 2020 онд хэрэгжүүлэх боломжтой байгаа тул бүтээн байгуулалтын санхүүжилттэй холбоотой асуудлыг 2020.09.10-ны өдөр Эрчим хүчний сайд Н.Тавинбэхд 163, 2020.09.23-ны өдөр Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэнд 170 дугаартай албан бичгээр тус тус уламжлан санал хүргүүлсэн.	100%
3.		Паркийн Эко-хот болох санаачлага болон уурхайн дэд бүтцийг ашиглах, ЭШСИИТ-ийн барилгын засварлан ашиглахад тулгарч буй асуудал, нийслэлийн концессын зүйлийн жагсаалтад тусгах 2 саналыг дэмжиж ажиллах тухай 162 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т 09 дүгээр сарын 10-ны өдөр уламжилсан.	100%
4.		Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсэд Багануур ХК-ийн одоо ашиглалтгүй байгаа дэд бүтцийг урт хугацааны гэрээгээр ашиглах талаар хамтран ажиллах, санал солилцох уулзалтыг Багануур ХК дээр 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтаар дараах асуудлыг хамтран шийдвэрлэхээр тогтов. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны ажлыг хийхэд шаардлагатай мэдээллүүдийг солилцох</li> <li>- Ажлын хэсэг гаргаж нарийвчилсан судалгаа хийх</li> <li>- Уурхайн ТУЗ-д танилцуулах</li> </ul>	100%



		Багануур ХК-д уурхайн дэд бүтцийг ашиглах талаар судалгаа жийхэд шаардлагатай холбогдох мэдээллүүдийн тодруулгыг авахаар саналыг 09 дүгээр сарын 28-ны өдрийн 179 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	
5.	БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	Байгууллагын хөгжлийн II дунд хугацааны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг удирдлагаар хянуулан 09 дүгээр сарын 10-ны өдөр батлуулав. Цаашид ЗГХЭГ-ын даргын 47 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу 2 бүлгийг боловсруулах ажлыг зохион байгуулна.	100%
6.	Гүйцэтгэлийн зорилт 3.2.4.1	Паркийн үйл ажиллагаагаар холбогдох БШУЯ-тай хамтран ажиллах уулзалтыг хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдон ачаалал ихтэй байгаа учир хугацааг 10 дугаар сараас тогтохоор болсон. Паркийн үйл ажиллагаагаар холбогдох БОАЖЯ-наас паркийн үйл ажиллагааг бодлогын хувьд дэмжин ажиллах бөгөөд хамтын ажиллагааны төлөвлөгөө батлуулах шаардлагагүй гэж үзсэн 06/6219 албан бичгийг 09 дүгээр сарын 14-ний өдөр парк шуудангаар хүлээн авсан. Уг бичгийн дагуу яамны холбогдох мэргэжилтэнтэй холбогдож санал солилцох уулзалтыг урьдчилсан байдлаар 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахаар тохироод байна.	50%
7.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-т 2020 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар хариутай 7, хариугүй 8 бичиг нийт 15 албан бичиг ирсэн ба шийдвэрлэлт 100 хувьтай байна. "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад хариугүй 26 албан бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна. Мөн 09 дүгээр сарын 02-ны өдөр 2 албан хаагчийн албан тушаалд өөрчлөлт оруулан ERP системд бүх бүртгэлийг шинэчлэв.	100%
8.	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1	baganuur-itr.mn цахим хуудасны хөгжүүлэлт, баяжилтыг тогтмол хийж, корона вирустэй холбоотой цаг үеийн мэдээг тасралтгүй хүргэж байна. Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс 3 дугаар улирлын байдлаар гаргасан биелэлтүүдийг байгууллагын цахим хуудсанд оруулсан.	100%
9.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт	Уг журмын 1 дүгээр хавсралтын дагуу дараах тайлангуудыг хугацаанд хүргүүлэв. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн мэдээ 4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ 5. Удирдлагын иргэдтэй хийсэн уулзалтын тайлан 6. Албан бичиг шийдвэрлэлтийн мэдээ 7. Нэг хот-Нэг стандарт зорилтот жилийн биелэлт	100%
10.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бусад үүрэгт ажлыг хугацаанд нь гүйцэтгэж ажилласан. Шилэн дансанд мэдээллийг агуулга, стандартын дагуу байршуулан, санхүүгийн 03 дугаар улирлын тайланг илгээхээр бэлтгэж байна.	100%



НЭМЭЛТ АЖИЛ

11.	Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гарагт zendmaal@gmail.com цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна.	100%
12.	Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн биелэлтийг 14 хоног бүр гарган НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.	100%
13.	НШУҮИГ-ын 02/323 дугаартай албан бичгийн дагуу холбогдох яамд, гадаадын хөрөнгө оруулагчидтай зохион байгуулах уулзалтын санал болон НШУҮИГ-тай хамтран ажиллах 4 дүгээр улирлын төлөвлөгөөг боловсруулан 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 156 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	100%
14.	Багануур дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс ирүүлсэн Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2020 оны 04 дүгээр зөвлөмжийг албан хаагчдад танилцуулсан. Хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллаж байна.	100%
15.	Багануур дүүргийн ТЗУХ-ээс ирүүлсэн 09 дүгээр сарын 03-ны өдрийн 04/64, 09 дүгээр сарын 04-ны өдрийн 04/65 дугаартай албан бичгүүдийн дагуу дүүргийн ТЗУХ-т Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 03 дугаар улирлын байдлаар гарган 09 дүгээр сарын 09-ний өдрийн 161 дугаартай албан бичгээр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр гарган 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 164 дугаартай албан бичгээр болон холбогдох цахим хаягаар тус тус хүргүүлсэн.	100%
16.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт, НИТХ-ын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 28/27 дугаар тогтоолоор батлагдсан хүснэгтийн дагуу Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 3 дугаар улирлын байдлаар гарган, товч танилцуулга бэлтгэн, даргын зөвлөлийн хурлын 07 дугаар тэмдэглэлийн хамт НЗДТГ-ын ХШ,ҮХ-т 09 дүгээр сарын 14-ний өдрийн 165 дугаартай албан бичгээр болон Munkhtuul9912@gmail.com хаягаар тус тус хүргүүлэв.	100%
17.	Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын систем, нийслэлийн дотоод удирдлагын нэгдсэн системийн ашиглалтын талаарх сургалтанд 09 дүгээр сарын 18-ны өдөр 3А-ны Ахлах мэргэжилтэн хамрагдав.	100%
18.	НОК-ын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлээр өгсөн зөвлөмжийг албан хаагчдад танилцуулав.	100%
19.	НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Эдийн засгийн хөгжил, үйлдвэрлэл, инновацийн бодлого хариуцсан мэргэжилтэн Б.Лхамсүрэн, Эрчим хүчний бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Тэмүүжин нартай 09 дүгээр сарын 21-ний өдөр уулзалт зохион байгуулж, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батбаясгаланд хүргүүлсэн хүсэлтэд дурьдсан төслүүдийн талаар санал солилцож холбогдох шийдвэрийг гаргасан.	100%
20.	БХБЯ-ны Барилга хөгжлийн төвд зураг төслийн талаар 09 дүгээр сарын 24-ний өдөр уулзалт зохион байгуулав.	100%
21.	Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын санхүүжилт болон тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг Уул уурхай, Хүнд үйлдвэрлэлийн сайд Г. Ёндон-д 2020.09.23-ны өдрийн 171 дугаартай албан бичгээр уламжилсан. Мөн тусгай зөвшөөрлийг сунгахтай холбогдсон баримт бичиг болох УУХҮЯ-тай байгуулсан гэрээний 2017-2020 оны биелэлтийг 3 дугаар улирлын байдлаар гарган 09 дүгээр сарын 28-ны өдрийн 178 дугаартай албан бичгээр Уул уурхай, Хүнд үйлдвэрлэлийн сайд Г. Ёндон-д, 09 дүгээр сарын 29-ний өдөр <a href="mailto:tumurbaatar.mm@gmail.com">tumurbaatar.mm@gmail.com</a> хаягаар илгээсэн.	100%



22.	2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Багануур дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг дүүргийн дарга нарын хурлаар хэлэлцүүлэв.	100%
23.	Монголын Үндэсний Их Сургуулийн багаас санаачлан хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээлэл, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, үзлэгийн үйл ажиллагаанд манай байгууллагаас 5 ажилтан хамрагдав. Эхо аппаратаар биеийн ерөнхий байдлаа хянуулж үзүүлэх сонирхолтой ажилтнууд байсан ч аппарат нь байхгүй байсан тул сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээллийг авсан.	100%
24.	Багануур дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээс 2020.09.23-ны өдөр зохион байгуулсан ehalamj.mn програм ашиглалт, хэрхэн нэвтэрч бүртгүүлэх талаарх сургалтад паркийн инженер мэргэжилтнүүд хамрагдав.	100%
25.	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явуулсан нийслэлийн салбар зөвлөлийн комиссоос ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн 2020 оны 03 дугаар улирлын тайланг Нийслэлийн архивын газарт 09 дүгээр сарын 25-ны өдрийн 175 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100%
26.	Багануур дүүргийн ГБХЗХ-ээс 2020.09.25-ны өдөр зохион байгуулсан "Залуучуудаа сонсох өдөр" нээлттэй хаалганы өдөрлөгт байгууллагынхаа салбар зөвлөлийн үйл ажиллагааг танилцуулан Эцэг эхийн зөвлөлүүдийн дунд зохион байгуулсан АХА тэмцээнд оролцон түрүүлсэн.	100%
27.	Монгол УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Л. Оюун-Эрдэнэ Багануур дүүрэгт 09 дүгээр сарын 25-ны өдөр ирж удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар паркийн удирдлага паркийн өнөөгийн байдал, статус, паркуудын асуудлыг төрийн бодлогоор яаж эрхлэх талаар санал дэвшүүлсэн.	100%
28.	2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн компост бордоог "Багануур тохижилт" байгууллагын төв магистраль автозам дагуух хамгаалалтын зурвасын модны тариалалтад ашигласан. Ургалтын явцыг улирал тутам хянаж байгаа ба 3 дугаар улирлын хяналтыг 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулав.	100%
29.	09 дүгээр сарын 30-ны өдөр байгууллагын ГБХЗХ-өөс "Бид хариуцлагатай хамт олон – Хүүхэд гэр бүлд ээлтэй орчин" арга хэмжээг зохион байгуулан амжиргааны түвшин доогуур нэг өрхөд хүнс тэжээлийн тусламж үзүүлэв.	100%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН  
ЗАХИРГААНЫ АДВАНЫ АХЛАХ МЭРГЭЖИДНИЙ  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э. ЭНХЗАЯА